

21. Эзэн минь, санхүүгийн бэрхшээлтэй тулгарсан Филиппины сонсогчдын итгэлийг бэхжүүлээч. Танд итгэж байгаа хүмүүсийн өдөр тутмынхан хэрэгцээг хангаж өгөөч. (Матай 6:33)

22. Монголын аавууд гэр бүлийнхээ өмнө үүрэг хариуцлагаа хүлээж, удирдаж чиглүүлдэг байгаасай гэж Бурхан танаас хүсэж байна. Мөн өрх толгойлсон ээжүүдэд үр хүүхдээ хүмүүжүүлэх хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь туслаарай гэж танаас гуйж байна. (Сургаалт үгс 4:1-9)

23. Аав аа, Солонгос дахь Христэд итгэгч дараагийн залуу үеийнхэнд хаант улсаа улам тэлэхэд шаардлагатай мэргэн ухаан, ур чадвар, хүчийг өгөөч. (Матай 9:38)

24. Эзэн минь, Японы өрх толгойлсон эхчүүд, ядууралд нэрвэгдсэн эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэр бүлүүдэд бие махбодын болон оюун санааны хамгаалалтыг өгөөч. Та тэдний хоргодох газар байх болтугай. (Дуу. 34:7-9)

25. Бурхан минь, Индонезийн багт “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрийг бэлтгэж байхад мэргэн ухаан, баяр баясгаланг өгөөч, мөн сонсогчдын Есүсийн талаарх мэдлэгийг улам гүнзгийрүүлэхэд нь туслаач. (2 Петр. 3:18)

26. Тэнгэрлэг Эцэг минь ээ, бид Энэтхэгийн үр хүүхэд гаргах боломжгүй эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Тэдэнд өөрийн гэсэн хүүхэдтэй болох урам зориг, итгэл найдвар, боломжийг өгөөрэй. (Дуу. 113:9)

27. Хятадад эмэгтэйчүүдийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсанд Бурханд баярлалаа. Энэ хууль хүйсийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтад өртөж буй хүмүүст бодит өөрчлөлтийг авчрах болтугай. (Дуу. 9:9)

28. Бурхан минь, Камбожийн сүмийн гишүүд болон удирдагчдын дунд эв нэгдлийг бий болгож өгөөч. Тэд хамтдаа санаа нэгтэйгээр таныг эрэлхийлэх болтугай. (Евр. 12:1)

29. Эзэн минь ээ, Таны эдгэрэл хэрэгтэй байгаа хүнд өвчтэй, хорт хавдартай, сэтгэл гутралд орсон Филиппиний “Найдвар доторх Эмэгтэйчүүд” нэвтрүүлгийн сонсогчдоо Есүс Христийн нэрээр ерөөж, бүрэн эдгэрэл, сэргээлтийг авчраач. (Ис. 53:5)

30. Эзэн минь, 2022 онд Сингапурын эмэгтэйчүүдэд бэлгийн халдлага, хүчирхийлэл эрс нэмэгдсэн тул тэднийг хамгаалж, айхгүй хүчтэй байхад нь туслаарай. (1 Петр 3:14)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Найдвартай
эмэгтэйчүүд

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2023. 6.

Азийн эмэгтэйчүүдэд зориулсан
залбирал 2

Энэ ертөнцөд хэн ч санамсаргүйгүйгээр төрдөггүй. Тэр бидний амьдралыг төрөхөөс ч өмнө төлөвлөж, одоо ч мөн удирдан чиглүүлдэг. Амьдралын туршид бидэнд унах ямар нэг асуудал үргэлж гардаг. Ийм үед бүү айгаарай. Бид Бурханы дээд эрх мэдлийг ойлгож, мэдэх тусам бидний амьдрал залбирал талархал, магтаалаар дүүрэн байх болно.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Аав аа, Вьетнамын эрх баригчид хүүхдийн хүчирхийллээс хамгаалах хууль тогтоомжийг санаачилж, батлах болтугай. Эцэг эхчүүдийн зүрх сэтгэл, оюун ухаанд нь хүүхдүүдэд хайрлаж, үнэ цэнийн мэдрүүлж, өсгөхөд туслах урам зориг мэргэн ухааныг хайрлаач. (Матай 18:10)

2. Непалийн шоронд хоригдож байгаа олон эмэгтэй хоригдлууд “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрийг сонсож, Есүсийг мэдэхээр ирж байгаад маш их баярлалаа, Эзэн минь! (Иохан 3:16)

3. Аав аа, Филиппин дэх TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” яаманд хөтөлбөр боловсруулах, сонсогчдыг судлах, тайлан бэлтгэх, залбирлын хуанли орчуулах, түгээх ажлыг хариуцах бүтэн цагийн ажилтнаар хангана уу. (Филиппой 4:6)

4. Бурхан минь, Монгол дахь Христэд итгэгч эмэгтэйчүүд танруу хандан залбирч, үгийг тань тунгаан бодож, өдөр бүр сайн мэдээг бусадтай хуваалцаж таны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нь урамшуулж, дэмжиж байхыг Танаас гуйж байна. (Марк 16:15)

5. Эзэн минь, “Найдвар доторх Эмэгтэйчүүд” нэвтрүүлгээр дамжуулан Хойд Солонгосоос Хятадад дүрвэж ирсэн эмэгтэйчүүдийг тайвшруулж, Есүс рүү хөтлөөсэй гэж бид залбирч байна. (Дуу. 119:49–50)

6. Аав аа, манай Японы TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” үйлчлэлийн багт яамны алсын харааг ойлгож, санхүүгийн хувьд болон сайн дураараа дэмжиж ажиллаж чадах хүмүүсийг авчраач. (Еф. 6:18)

7. Эзэн минь, та бидний хоргодох газар юм. Индонезид болсон байгалийн гамшгийн улмаас дүрвэгсдийн хуаранд амьдарч буй сая сая эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хоол хүнсээр хангаж, эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлж өгнө үү. (Дуу. 46:1)

8. Бурхан минь ээ, Энэтхэгийн Гужарати дахь “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрийн багийн гишүүдийг бүс нутгийн тусламж хэрэгтэй эмэгтэйчүүдэд үр дүнтэй хүрч үйлчихийн тулд ашиглаасай гэж хүсэж байна. (1 Тим. 1:12)

9. Манай баг 2023 оны 7-р сараас эхлэн Уйгур хэл дээр “Найдвар доторх Эмэгтэйчүүд” нэвтрүүлэг радиогоор цацагдаж эхэлнэ гэж найдаж байна. Хятадын Уйгур эмэгтэйчүүдэд нэвтрүүлгийг сонсох мөн Есүсийн тухай мэдэх боломжийг олгож өгөөч. (Ром. 10:17)



10. Эзэн минь, Камбожийн “Найдвар доторх Эмэгтэйчүүд” багийнхны санхүүгийн хэрэгцээг хангаач. Та бол Ирагийн хувьд Ехова бөгөөд тэдний итгэл найдварын эх сурвалж билээ. (Эх. 22:14)

11. Аав аа, Та биднийг маш их үнэ цэнтэйгээр хайрлаж, элбэг хангалуун амьдралд дуудсан билээ. Балбын эмэгтэйчүүд Бурханы үнэнийг хүлээн зөвшөөрч, өөрсдийг нь хоёр дахь зэрэглэлийн иргэд гэж ойлгуулсан худал хуурмагийг няцааж, ямар их үнэ цэнэтэй гэдгээ ойлгох болтугай. (Иохан 10:106)

12. Эзэн минь, Филиппиний сүм, засгийн газар тусламж хэрэгтэй байгаа биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийг өрөвдөж, энэрч, туслах болтугай.

Эдгээр эмэгтэйчүүд ийм амьдралаасаа чөлөөлөгдөх болтугай. (Сургаалт үгс 14:21).

13. Аав аа, Монголд байгаа Христийн шашны үйлчлэлийг хүчирхэгжүүлээч. Сайн мэдээг сонссон хүмүүс Сатаны хүлээсээс чөлөөлөгдөж, Есүсийг Аврагч гэж хүлээн зөвшөөрөх болтугай. (Иохан 11:27)

14. Их Эзэн минь, Японы радио болон YouTube суваг дээр цацагдаж байгаа “Найдвар доторх Эмэгтэйчүүд” нэвтрүүлэгт сонсогчид хариулж, сэтгэгдлээ илэрхийлсэнд мөн сайн дурынхан болон зуучлан залбирагчид ивээгдэж байгаад бид Таныг магтъя. (Дуу. 103:1).

15. Бид Индонези болон Яван дахь “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрийг санхүүжүүлдэг үнэнч хандивлагчдын төлөө Бурхан Таныг магтъя. (Евр. 13:15).

16. Эзэн минь, бид Хойд Энэтхэгт нөхрүүд болон хөвгүүд нь хар тамхинд донтсон эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Эдгээр залуучуудад эдгэрлийг авчраач. (Исаиа 61:1).

17. Бурхан минь, шоронд хоригдож байгаа солонгос эмэгтэйчүүдэд мэргэн ухааныг өгөөч. Сайн мэдээг сонсож, Есүсийг Аврагч гэж хүлээн авахын тулд хоригдлуудын зүрх сэтгэлийг нээж өгөөч. (Исаиа 42:7).

18. Залбирлын хуанли дахь хүсэлтийг Хятад хэлээр бүртгэх сайн дурын ажилтан өгсөнд Бурханд маш их талархаж байна. Одоогийн байдлаар нэг минутын аудио залбирлыг онлайн аар нийтэлсэн бөгөөд удахгүй радиогоор цацах болно. (1 Петр 4:10)

19. Аав аа, Камбожид албадан хөдөлмөр эрхлүүлэх, хүний наймаанд явуулж, бэлгийн мөлжлөгт боолчлогдож байгаа залуу эмэгтэйчүүдийг авраач, чөлөөлж өгөөч. (Дуу. 90:2).

20. Аав аа, зовж шаналж буй эмэгтэйчүүдэд уйгагүй үйлчилдэг Балбын багийг сэргээж, хүчирхэгжүүлж, урамшуулаарай. (Иер. 31:25).